



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

3. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.

4. Тушаалын үнэт цаасны бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

1150590151

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2013 оны 06 сарын 18 өдрийн
25 тоот тушаалын нэгдүгээр хавсралт




ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН
НЭГЖИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

2013.6.17

Улаанбаатар хот

д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Эм Эм Эм Ди ХХК	Кайзер	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 10/2в
2	Эгшиг гранд ХХК	Нью ворлд	Сүхбаатар дүүрэг, 10-р хороо, 7-р хороолол, Цагдаагийн гудамж 31
3	Малик трейд ХХК	Агате	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 13/1
4	Сан-Хорго ХХК	Сан	Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Их тойруу 47
5	Эко стар ХХК	Эко стар	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу 46/4

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2013 оны 06 сарын 18 өдрийн
35 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

2013.6.17

Улаанбаатар хот

д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Э.Энхтуяа	Уянга	Сүхбаатар дүүрэг, 10-р хороо, Барилгачдын 82Б
2	Ева центр ХХК	Ион	Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Их тойруу 190
3	Пийсвинд ХХК	Алтан говь	Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 1-р дөчин мянгат 13/2
4	Төгс сайн ХХК	Төгс сайн	Баянгол дүүрэг, 7-р хороо, Дилав хутагт Жамсранжавын гудамж 05
5	Түмэн сант тэнгэр ХХК	Саран	Баянзүрх дүүрэг, 13-р хороо, Алтан тэвш хороолол 21
6	Иргэн Д.Рэгзэдмаа	Пилимоне	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, 386